



# СОЁМБО

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

№02 /216/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.01.04

Цаг үе, үйл явдал

## ЦЭРГИЙН БҮРТГЭЛИЙГ ЦАХИМЖУУЛЖ, "E-MONGOLIA" СИСТЕМД НЭГТГЭЛЭЭ



Цэргийн штабын дарга, хурандаа Г.Ялалт "Цэргийн бүртгэл энэ оны 1 дүгээр сарыг дуустал явагдана. Цэргийн бүртгэлд 18-55 хүртэлх насны иргэд хамрагдах ёстой. Эдгээр иргэд маань "e-Mongolia" системийг ашиглан цахимаар бүртгүүлэх боломжийг бүрдүүлээ. Харин интернэтийн хүртээмжгүй орчинд амьдарч буй эсвэл цахимаар тус үйлчилгээг авах боломжгүй иргэд нийслэлийн үйлчилгээний зургаан төвд биечлэн очиж, бүртгүүлэх боломжтой. Мөн 18 нас хүрч буй иргэн хороондоо очиж бүртгүүлэн, цэргийн үүрэгтний үнэмлэхээ нээлгэж авах ёстой" гэсэн мэдээллийг өглөө. Үүний дараа Харилцаа холбоо,

мэдээллийн технологийн газрын "e-Mongolia" төслийн нэгжийн бизнес аналит Б.Батзул "Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар иргэдийн хувьд хамгийн эрэлттэй буй төрийн үйлчилгээг цахимжуулж байгаа. Энэ удаа бид Батлан хамгаалах яамнаас иргэдэд үзүүлдэг "Цэргийн бүртгэл"-ийн үйлчилгээг цахимжууллаа. Цэргийн бүртгэлийн хүсэлтийг бид гурван төрлөөр авах боломжтой. Тодруулбал, нэгдүгээрт, "e-Mongolia" гар утасны аппликейшн, хоёрдугаарт www.e-Mongolia.mn сайт, гуравдугаарт, 21 аймаг, нийслэл Улаанбаатар хотын төв болон 330 сум дээр байрлаж буй төрийн үйлчилгээний оператор

2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрөөс улс орон даяар цэргийн бүртгэл эхлэхтэй холбогдуулан Батлан хамгаалах яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газраас өнөөдөр хэвлэлийн хурал зохион байгууллаа. Тус хуралд Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн хурандаа С.Рагчаадорж, Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга хурандаа Г.Ялалт, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын "e-Mongolia" төслийн нэгжийн бизнес аналит Б.Батзул нар оролцож, энэ жилийн цэргийн бүртгэлийг биечлэн болон цахимаар зохион байгуулах талаар мэдээлэл өглөө.

хэлбэрээр үзүүлэх эхний үйлчилгээ бол Цэргийн бүртгэл юм. Цэргийн бүртгэлийг бид улс орон даяар цахим хэлбэрээр зохион байгуулах боломжийг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газартай хамтарч, өнөөдөрөөс нээж байна. Өмнө нь цэргийн бүртгэл хэрхэн явагддаг байсныг та бүхэн мэднэ. Тухайлбал, цэргийн бүртгэлд бүртгүүлэх ёстой иргэн бүр өөрийн биеэр хороо, сумынхаа тамгын газарт очиж, бүртгүүлдэг байсан бол өнөөдөр "e-Mongolia" системийг ашиглан гар утас эсвэл суурин компьютероосоо шууд бүртгүүлэх боломжтой болсон. Батлан хамгаалах яам эхний ээлжид цэргийн тоо, бүртгэлийг цахим хэлбэрт шилжүүлж байна. Цаашид Батлан хамгаалахын төв архиваас алба хаасан тухай лавлагаа авах зэрэг цахимаар авах боломжтой үйлчилгээнүүдийг "e-Mongolia" системд нэгтгэхээр хамтран ажиллаж байна" гэв.



ажилтнуудаар дамжуулан тус үйлчилгээг авах боломжтой. Интернет орчинд "e-Mongolia" систем рүү нэвтэрч чадахгүй, ашиглаж мэдэхгүй иргэн байвал нийслэл болон 21 аймаг, 330 суманд байрлаж буй "e-Mongolia"

системийн операторуудад хандаж, тус үйлчилгээг авах боломжтой" гэв. Дашрамд дурдахад, цэргийн бүртгэл нь 2022 оны 01 дүгээр сарын 05-22-ны өдрүүдэд үргэлжилнэ.

Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн хурандаа С.Рагчаадорж "Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем "e-Mongolia"-д Монгол Улсын Батлан хамгаалах яам нэгдлээ. Батлан хамгаалах яамнаас цахим

Үүний дараа Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын

## АЛБА ХААЖ БАЙГАА ЦЭРГҮҮДДЭЭ ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ



**Өвөрхангай аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб** Өвөрхангай аймгийн Цэргийн штаб, Арвайхээр, Зүүнбаян-Улаан, Тарагт сумын Засаг даргын Тамгын газрын дарга нар болон багийн дарга нарын төлөөлөл хамтран шинэ жилийн баярыг тохиолдуулан 2021 оны ээлжит цэрэг татлагаар Өвөрхангай аймгаас Зэвсэгт хүчний 256 дугаар ангид татагдан хугацаат цэргийн алба хааж байгаа дайчдад хүндэтгэл үзүүлэх үйл ажиллагааг зохион байгууллаа.

Цэрэг дайчдад аймгийн Засаг даргын мэндчилгээг уламжлан Өвөрхангай аймгийн 2021 оны бүтээн байгуулалт, ололт амжилтын талаар видео бичлэг үзүүлж, уулзалт ярилцлага зохион байгуулан санал сэтгэгдлийг

нь сонсож, дайчдын ар гэрийн мэндчилгээ, илгээмжийг гардуулан өгч, сэтгэл зүйн томоохон дэмжлэгийг үзүүлж ажиллалаа. Цэргийн штабаас цэрэг дайчдадаа хүндэтгэл үзүүлж, амны хаалт, баярын ширээний амттан болон албаа шүлгэр жишээчээр хааж байгаа дайчдад гарын бэлэг гардуулан өглөө.

Дэд хурандаа Ч.ВАНЧИНСҮРЭН



## МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН  
2.266.225 /69.7%/

ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН  
2,164.363 /66.5%/

ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН  
919.478 28,3%

## ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН  
7190 +112

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ  
262

ЭДГЭРСЭН  
6710

## КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол  
Нийт: 292,996,156

Эдгэрсэн  
Нийт: 255,418,460

Нас барсан  
Нийт: 5,465,963

Түүхэнд энэ өдөр

1997 он.

БХЯ-ны харьяа "Дуулга" студийн "Эх орны төлөө" нэвтрүүлэг МҮОНТ-ээр анх удаа цацагдав.

## ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-11	-26

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
37	22

## ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,846.0	2,851.0
EUR	3,222.0	3,235.0
CNY	431.00	436.10
RUB	36.38	38.43
JPY	24.70	24.80
KRW	2.37	2.39

## ЗУРХАЙ

2022.01.04 МЯГМАР ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 2/

ӨВЛИЙН АДАГ ЦАГААГЧИН ҮХЭР САРЫН НАЙМАН ЦАГААН МЭНГЭТЭЙ УЛААГЧИН МОГОЙ ӨДӨР

Үс засуулбал:

Хэл,ам,хэрүүл тэмцэл ирнэ НАРАН УРГАХ, ШИНГЭХ: 08.41-17.12  
Барилдлага: Түлэх ШҮТЭН БАРИЛДЛАГА: Хуран үйлдэхүй Суудал: Шороо

Энэ өдөр үхэр жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр гэмт хэрэг илрүүлэх, гэм буруутныг шийтгэх, сан тавиулах, угаал үйлдэх, газар лусын зан үйл хийх, өр барагдуулах, буг дарах, газрын ам бооход сайн. Ургаа мод таслах, газрын ам нээх, сэтгэлд сэтгэй газар очих, байшингийн суурь тавихад муу.

Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Хол газар яваар одогосод баруун зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

Цахим шууданд

# 2022 ОНЫХОО АНХНЫ БУУДЛАГЫГ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



### Зэвсэгт хүчний 340 дүгээр анги

Ангийн 2021-2022 оны сургуулийн жилийн сургалтын төлөвлөгөөний дагуу бие бүрэлдэхүүний бэлэн байдлыг дээшлүүлэх, хүн нэг бүрийн ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор "Цугларалт" дохиогоор ажиллаж офицер, ахлагч нарын буудлагыг ПМ гар буу болон автоматын нэгдүгээр дасгалаар, 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр Хилийн 0165 дугаар ангийн буудлагын талбайд амжилттай зохион байгууллаа.

Мөн буудлагын үеэр тактикийн анхан шатны нэгж болох салаа тасгийн зохион байгуулалттайгаар байлдааны талбарт явганаар хөдөлгөөн үйлдэх арга ажиллагааг дадлагын хэлбэрээр зохион байгуулж




явуулсан.

Буудлагын ахлах удирдагчаар захирагчийн орлогч, ерөнхий инженер хошууч М.Гончигсум удирдсан бөгөөд буудлага хийх бүрэлдэхүүнд буудлагын үед дагаж мөрдөх аюулгүйн арга

хэмжээний дүрэм, зааврыг сайтар судлуулан хүн нэг бүрд аюулгүй ажиллагааны зааварчилгааг танилцуулж гарын үсгийг зуруулж баталгаажуулан ажиллаа.

**Ахлах дэслэгч Б.ДОЛГОРСҮРЭН**



### Байлдагч ярьж байна

## Э.БАТЦООЖ: ҮНЭХЭЭР СЭТГЭЛД ХОНОГШСОН БАЯР БОЛЖ ӨНГӨРЛӨӨ

### Зэвсэгт хүчний 340 дүгээр анги

Юуны өмнө Увс аймгийн Наранбулаг суманд суугаа хайртай гэр бүлдээ болон 2021 онд цэргийн жинхэнэ албанд татагдсан нийт байлдагчдаа Шинэ оны баярын мэндийг хүргэе.

Байлдагч Энхбат овогтой Батцож миний бие Увс аймгийн Наранбулаг сумаас тус ангийн ахмад Б.Ууганбаатар захирагчтай Инженер сапёрын ротын II салаанд цэргийн

албанд татагдан ирсэн. Бидний шинэ жилийн баярын хүндэтгэлийн үйл ажиллагаа үнэхээр сэтгэлд хоногшсон баяр болж өнгөрлөө. Энэхүү баярын үеэр би супер азын сугалаа /№ 64-г атгаж чадсандаа үнэхээр их баяртай байна. Яагаад гэвэл өмнө нь огт азтан болж байгаагүй хүн л дээ, би.../ Инээв/. Аз хийморио сорьсон, үнэхээр мартагдахааргүй сайхан шинэ жилийг онжавуудтайгаа болон ангийн удирдлага, хамт олонтойгоо инээд хөөр, аз

жаргалаар дүүрэн тэмдэглэн өнгөрүүлээ.

Намайг цэргийн албанд татагдахаас өмнө аав минь социализмын үеийн цэргийн дарга нар хамгийн сайн хүмүүс байсан талаар надтай яриа өрнүүлж билээ. Би Зэвсэгт хүчний 340 дүгээр ангид ирэхээсээ өмнө битүүхэндээ жаахан айдастай байсан. Гэтэл энд ирээд дарга нарынхаа бидэнтэй хүндэтгэлтэй харьцаж байгаа, цэргийн эрдэмд сургахаас гадна амьдралын ухаан, цаашлаад нийгэмд байр

Зэвсэгт хүчний Төрөл мэргэжлийн холбоонуудын дунд жил бүр уламжлагдан зохион байгуулагддаг Гар бөмбөгийн аварга баг шалгаруулах тэмцээнд баг тамирчдаа оролцуулахыг урьж байна.

## МОНГОЛЫН АРТИЛЛЕРИЙН ЦЭРГИЙН ХОЛБООНООС ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАР БӨМБӨГИЙН ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ

### НЭГ: ЗОРИЛГО

Ахмад настнуудын эрүүл мэнд, хөдөлгөөн, бие бялдрыг хөгжүүлэх, тэдний амралт чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штабын Ахмадын хороотой хамтран Төрлийн цэргийн мэргэжлийн холбоодын дунд зохион байгуулахад оршино.

### ХОЁР: ТЭМЦЭЭНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Тэмцээнд орох баг нь Цэргийн холбоод, харьяаллын анги, байгууллагуудаас цэргийн болон тэтгэвэрт гарсан ахмадуудаас бүрдэнэ.

- 1.Баг нь 8 хүртэлх хүний бүрэлдэхүүнтэй 55-аас дээш настнууд хамрагдах байх ба 1-2 эмэгтэй оролцуулж болно. /эмэгтэй нь 50-аас дээш настай байна/
- Цэргийн холбоо 2 баг оролцуулж болно.
- 2.Багууд таних тэмдэгтэй, жигд хувцастай байна.
- 3.Тэмцээнийг улсын зэрэгтэй мэргэжлийн шүүгч шүүнэ.

### ГУРАВ: ТЭМЦЭЭН ЯВАГДАХ ХУГАЦАА, ТОГЛОХ ЖУРАМ

- 1.Тэмцээн 2022 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн бямба гаригт "Алдар" спорт

БАТЛАВ.

МЭРГЭЖЛИЙН ХОЛБООНЫ ДАРГА.....

огноо

...../ЦЭРГИЙН ХОЛБООНЫ НЭР/ МОНГОЛЫН АРТИЛЛЕРИЙН ЦЭРГИЙН ХОЛБООНООС ЗОХИОН БАЙГУУЛАХ АХМАДЫН ГАР БӨМБӨГИЙН ТЭМЦЭЭНД ОРОЛЦОХ БАГ ТАМИРЧДЫН МЭДҮҮЛЭГ

Д/д	Овог нэр	Регистрын дугаар	Спортын зэрэг	Хувийн дугаар	Эмчийн дүгнэлт
1					
2					
3					
4					
5					
6					
7					
8					

БАГИЙН ДАСГАЛЖУУЛАГЧ.....

БАГИЙН АХЛАГЧ .....

хорооны "А", "Б" зааланд зохион байгуулна. Оролцох багийн тооноос хамааран өдөр сунгагдаж болно.

- 2.Тоглох журмыг багуудын тооноос хамааран техникийн зөвлөгөөн дээр шийдвэрлэнэ.
- 3.Техникийн зөвлөгөөнийг 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 14.00 цагт Офицеруудын ордны 2 давхрын "Соёмбо" хурлын танхимд болно.
- 4.Багууд техникийн зөвлөгөөнд ирэхдээ мэдүүлгийн хамт иргэний үнэмлэхийн хуулбар авчирна. /Мэдүүлгийг хавсралтад заасан загварын дагуу боловсруулсан байна/
- 5.Багууд тэмцээний хураамж 80 000 /наян мянга/ төгрөгийг техникийн зөвлөгөөн дээр авчирна. /Тэмцээний нарийн бичгийн шүүгч тусгай маягтад тэмдэглэл хийж хураамжийг авах болно/

### ДӨРӨВ: ТЭМЦЭЭНИЙ ШАГНАЛЫН САН

- 1.Багийн дүнгээр тэргүүлсэн багт "ШИЛЖИН ЯВАХ ЦОМ", "ДУРСАМЖ" олгоно.
- 2.Тэмцээнд оролцсон багуудыг 1-3 дугаар байраар шалгаруулна. Нэгдүгээр байр: Өргөмжлөл, 150 000 төгрөг Хоёрдугаар байр: Өргөмжлөл, 120 000 төгрөг Гуравдугаар: Өргөмжлөл, 100 000 төгрөг /Тэмцээнд оролцох багийн тооноос хамаарч шагналын санг нэмж болно/

### ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:

МОНГОЛЫН АРТИЛЛЕРИЙН ЦЭРГИЙН ХОЛБОО бэлтгэлд байгаа хурандаа Ж.Ванчинсүрэн 99036029, бэлтгэлд байгаа хурандаа Ө.Батмөнх 88050544



**Ахлах дэслэгч Б.ДОЛГОРСҮРЭН**